Алтай сумын Засаг дарга нь Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль бусад холбогдох хууль, тогтоомжуудын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь тус аймгийн төсөвт байгууллагуудын санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага ба тайлант онд Алтай сумын Засаг даргын харьяа байгууллагуудад хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Алтай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Алтай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Сангийн сайдын 2023 оны 65 дугаар “Хөтөлбөр батлах тухай” тушаалаар аккруэл суурьт УСНББОУС-ыг нэвтрүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг баталсан байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Алтай сумын Засаг даргын тамгын газрын даргын 2018 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/59 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Алтай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дугаар тушаалаар баталсан “Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна..

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,659.6 сая төгрөгөөр буюу 162 хувиар өссөн байна.

Хүснэгт №1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	167.60	111.78	(55.82)
Авлага	167.77	205.50	37.73
Бараа материал	26.76	107.28	80.52
Үндсэн хөрөнгө	1,230.31	3,827.50	2,597.19
Нийт хөрөнгө	1,592.43	4,252.06	2,659.63
Өр төлбөр	8.75	7.41	(1.34)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,583.68	4,244.65	2,660.97
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,592.43	4,252.06	2,659.63

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо дансдад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Алтай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 111.8 сая төгрөг болж, оны эхнээс 55.8 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
Кассад байгаа бэлэн мөнгө	-	-	-
Банканд байгаа бэлэн мөнгө	167.60	111.78	-55.8
Төгрөг	167.60	111.78	-55.8
Төрийн сангийн харилцах	167.48	111.78	-55.7
Нэмэлт санхүүжилтийн харилцах	0.12	0	-0.1
Дүн	167.60	111.78	-55.8

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Орон нутгийн ерөнхий орлогын данс 45.7 сая, ОНХС-гийн данс 14.3 сая, Хоршоо хөгжүүлэх сан 51.8 сая төгрөгөийн үлдэгдэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

- Мөнгөн хөрөнгө данстай холбоотой зөрчил гараагүй.

3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 205.5 сая төгрөг болж, өмнөх оноос 37.7 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчтай холбогдсон авлага	0	1.0	-
Төлбөртэй үйлчилгээний авлага	0	0.1	-
Зээлийн авлага	167.8	204.4	36.7
Хувь хүмүүст олгосон зээл	167.8	204.4	36.7
Дүн	167.8	205.5	37.7

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Авлагын дансны үлдэгдэл өмнөх оноос 37.7 сая төгрөгөөр нэмэгдсэн нь сумын Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн авлага 36.7 сая, ажиллагчтай холбоотой авлага 1.0 сая, төлбөртэй үйлчилгээний авлага 0.1 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

- Сумын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар авлага данстай холбоотой зөрчил гараагүй.
- Сумын ЗДТГ-ын санхүүгийн тайланд хийсэн аудитаар цалингийн урьдчилгааны авлагад тусгаагүй 0.3 сая, цалингаас суутгасан хувь хүний орлогын албан татварыг илүү шилжүүлсэн 0.7 сая төгрөгийн алдааг залруулсан.

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилж гарсан зардал дансанд өөрчлөлт ороогүй байна.

Алтай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 107.3 сая төгрөг болж, оны эхнээс 80.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	14.3	7.5	-6.7
Эм боох материал	14.3	7.5	-6.7
Хангамжийн материал	12.5	99.7	87.2
Аж ахуйн материал	10.5	10.9	0.3
Бусад хангамжийн материал	2.0	88.9	86.9
Дүн	26.8	107.3	80.5

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Бараа материалын данс 80.5 сая төгрөгөөр өссөн нь сумын ЗДТГ 86.9 сая төгрөгийн бусад хангамжийн материалыг үнэ төлбөргүй хүлээн авсантай холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

Бараа материал данстай холбоотой зөрчил гараагүй.

3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө:

Бусад эргэлтийн хөрөнгийн данс оны эхэн ба эцэст үлдэгдэлгүй байна.

3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 4,930.1 сая төгрөг болж, өмнөх оноос 2,744.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	2,177.02	4,919.95	2,742.94
Барилга, байгууламж, орон сууц	1172.1	1279.9	107.8
Авто-тээврийн хэрэгсэл	209.3	247.7	38.4
Машин тоног төхөөрөмж(компьютер)	352.9	442.0	89.1
Тавилга, аж ахуйн эд хогшил	43.0	43.4	0.4
Зам, гүүрийн байгууламж	267.70	2,774.92	2507.2
Бусад үндсэн хөрөнгө	131.7	131.7	0.0
Ном	0.4	0.4	0.0
Биет бус хөрөнгө	8.8	10.2	1.4
Программ хангамж	1.9	3.3	1.4
Бусад биет бус хөрөнгө	6.9	6.9	0.0
Дүн	2,185.77	4,930.13	2,744.36

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Үндсэн хөрөнгийн данс 2,744.4 сая төгрөгөөр өссөн нь ЗДТГ-ын төсвийн хөрөнгөөр худалдан авсан хөрөнгө болон аймаг, сумын ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Алтай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын илрүүлэлт:

- Үндсэн хөрөнгө данстай холбоотой зөрчил гараагүй.

3.5.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн данс оны эцэст 7.4 сая төгрөг болж, 1.3 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	/ сая төгрөгөөр /		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Өглөг	2.8	1.7	(1.1)
Ажилчидтай холбогдсон өглөг	2.8	1.7	(1.1)
Бусад өглөг	5.9	5.7	-0.2
Байгууллагад төлөх өглөг	5.9	5.7	-0.2
Дүн	8.7	7.4	-1.3

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Ажилчидтай холбоотой 2.8 сая төгрөгийн хувь хүний орлогын албан татварын өглөгийг барагдуулж, оны эцэст нийгмийн даатгалын шимтгэлд 1.7 сая төгрөгийн өртэй гарсан ба байгууллагад төлөх 5.9 сая төгрөгийн өр төлбөр 0.2 сая төгрөгөөр буурсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Сумын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар өр төлбөр данстай холбоотой зөрчил гараагүй.
- Сумын ЗДТГ-ын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг зөрүүтэй тусгасан 0.3 сая төгрөгийн алдааг залруулсан.

3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 4,244.6 сая төгрөг болж, тайлант оны үр дүнгийн хэмжээгээр 2,660.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	/ сая төгрөгөөр /		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	452.6	452.6	0.0
Хуримтлагдсан үр дүн	887.29	3,548.26	2,660.97
Өмнөх үеийн үр дүн	851.26	887.29	36.03
Тайлант үеийн үр дүн	36.03	2,660.97	2,624.94
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	243.75	243.75	0.00
Дүн	1,583.7	4,244.6	2,660.97

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Алтай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Алтай сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрт зориулан нийтдээ 1,640.3 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1,288.3 сая төгрөгийг урсгал зардалд, 352.0 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 514.6 сая төгрөгийг улсын төсвийн санхүүгийн дэмжлэгээр, 675.2 сая төгрөгийг сумын орон нутгийн төсвийн орлогоос, 315.5 сая төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлэхээр, 108.0 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэн, 27.0 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Алтай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2023 онд гүйцэтгэлээр нийтдээ 1415.9 сая төгрөгийн санхүүжилтийн орлого бүрдүүлснээс улсын төсвөөс 514.6 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авч, сумын орон нутгийн төсвөөс 534.7 сая төгрөгийн, Орон нутгийн хөгжлийн сангаас 315.5 сая төгрөгийн санхүүжилт хүлээн авч, үндсэн үйл ажиллагааны орлогоос 51.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урьд оны үлдэгдлээс 41.9 сая төгрөгийг зарцуулсан байна.

Орон нутгийн төсвөөс авахаар төлөвлөсөн санхүүжилтээс 140.5 сая төгрөгийг дутуу авч, оны эцэст орон нутгийн төсвөөс авсан санхүүжилтээс 26.0 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Хоршоо хөгжүүлэх сангаас орох үндсэн үйл ажиллагааны орлогыг 108.0 сая төгрөгөөр төлөвлөснөөс 51.1 сая төгрөг оруулж, 56.9 сая төгрөгөөр тасарсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,457.8 сая төгрөг буюу 89 хувьтай байгаа нь дутуу авсан санхүүжилт болон төвлөрүүлэх шилжүүлэг, тасарсан орлого, эхний үлдэгдлээс зарцуулсантай холбоотой байна.

Аудитын илрүүлэлт

- *Сумын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар зөрчил гараагүй.*
- *Сумын ЗДТГ-ын санхүүгийн тайланд хийсэн аудитаар батлагдсан төлөвлөгөөг 1.0 мянган төгрөгөөр, санхүүжих эх үүсвэрийг 102.8 сая төгрөгөөр дутуу, төсвийн гүйцэтгэлийг 18.9 сая, санхүүжих эх үүсвэрийг 25.9 сая төгрөгөөр илүү тайлагнасан алдааг залруулсан.*
- *Сумын ЗДТГ-ын санхүүгийн тайланд хийсэн аудитаар цалингийн зардлаас илүү шилжүүлсэн 1.3 сая төгрөгийн хувь хүний орлогын албан татварын тооцооноос газрын төлбөрийн 578.5 мянган төгрөгийг төлсөн зөрчлийг давтан гаргахгүй байх талаар зөвлөмж өгсөн.*

Сумын орон нутгийн төсвийн орлогын талаар:

Үндсэн үйл ажиллагааны орлогоос 51.1 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн нь Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс орсон орлого байна.

Аймгийн ИТХ-ын 2022 оны “Орон нутгийн төсөв батлах тухай” 132 дугаар тогтоолоор Алтай сумын 2023 оны орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 604.0 сая төгрөгөөр баталж, Аймгийн ИТХ-ын хуралдааны “2022 оны төсөвт тодотгол хийх тухай” 2023 оны 192 дугаар тодотголоор 4.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж 608.8 сая төгрөгөөр тодотгож баталсан байна.

Сумын ИТХ-ын 2022 оны 53 дугаар тогтоолоор 2023 орлогын төлөвлөгөөг 604.0 сая төгрөгөөр баталсан бол сумын ИТХ-ын 2023 оны 61 дүгээр тогтоолоор 2023 орлогын төлөвлөгөөг анх баталснаас 21.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж 625.2 сая төгрөгөөр тодотгож баталсан байна.

Алтай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

3	Хоршоог хөгжүүлэх сан	108.00	80.48	(27.52)	75%
4	ОНХСан	352.01	337.49	(14.51)	96%
	Орон нутгийн дүн	1,278.36	1,097.76	(180.59)	86%
1	Ерөнхий боловсролын 1-р сургууль	226.31	224.35	(1.96)	99%
2	Ерөнхий боловсролын 2-р сургууль	21.41	21.41	-	100%
3	Хүүхдийн цэцэрлэг	48.11	48.11	-	100%
4	Соёлын төв	32.52	32.52	-	100%
5	Эрүүл мэндийн төв	33.63	33.63	-	100%
	Тусгай шилжүүлгийн дүн	362.00	360.04	(1.96)	99%
	Нийт дүн	1,640.35	1,457.80	(182.55)	89%

Алтай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2023 онд нийт 1,640.4 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр 1,457.8 сая төгрөгийн төсвийг зарцуулж 88.9 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна. Үүнд: Сумын ИТХ 9.8 сая, ЗДТГ 128.7 сая, Хоршоог хөгжүүлэх сан 27.5 сая, Орон нутгийн хөгжлийн сан 14.5 сая төгрөгөөр төлөвлөснөөс бага гүйцэтгэлтэй гарсан байна.

Сумын ЗДТГ 716.5 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр 587.8 сая төгрөгийн санхүүжилт авч төсвийн нийт зардлын гүйцэтгэл 82 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Энэ нь орон нутгийн төсвөөс 128.7 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу олгож, авсан санхүүжилтээс 25.9 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Сумын ИТХ 101.9 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр 91.9 сая төгрөгийн санхүүжилт авч төсвийн нийт зардлын гүйцэтгэл 90 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Сумын Орон нутгийн хөгжлийн сан төлөвлөснөөс бага гүйцэтгэлтэй гарсан нь зарцуулалттай холбоотой. Хоршоог хөгжүүлэх сан төлөвлөснөөс бага гүйцэтгэлтэй гарсан нь зээлийн эргэн төлөлтөөс орсон орлогын гүйцэтгэлтэй холбоотой байна.

Ерөнхий боловсролын сургуулийн төсвийн гүйцэтгэл 99 хувийн гүйцэтгэлтэй гарсан нь орон нутгийн төсвөөс авах санхүүжилтээ 1.9 сая төгрөгөөр дутуу авсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд ИТХ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд засаг даргын нөөц хөрөнгө, түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс 3.5 сая, сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчийн төсвөөс доод шатны төсвийн захирагчийн төсөвт хуваарилсан хөрөнгөөс 10.2 сая, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 29.1 сая төгрөгийн нийтдээ 42.8 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авч оны эхний үлдэгдэлд байсан 0.1 сая төгрөг, нийт 42.9 сая төгрөгийн нэмэлт төсөв авсан байна. Үүнээс: Тээвэр шатахууны зардалд 9.5 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 33.3 сая, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд 0.1 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн гүйцэтгэл, орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Алтай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Алтай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2023 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Алтай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Назгүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Алтай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн тайланг 2024 оны 3 дүгээр сарын 01-ний өдрийн 25 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Алтай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 8,149.6 сая төгрөгөөс 1 хувиар буюу 81.5 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатанд Алтай сумын ТТЗ-ийн 2023 оны нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,268.8 сая төгрөгөөс 1 хувиар тооцоход материаллаг байдлын түвшин 12.7 сая төгрөг байна

Энэ нь төлөвлөлтийн үе шатанд төлөвлөсөн материаллаг байдлын түвшнээс 68.8 сая төгрөгөөр бага байгаа тул материаллаг байдлын түвшинг аудитын явцад дахин хянаж гүйцэтгэлийн үе шатанд 12.7 сая төгрөгөөр шинэчлэн тогтоов.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор сумын төсөв байгууллагууд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй батлагдсан төсөвтөө багтаан үйл ажиллагаа явуулсан байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах асуудлын хүрээнд үйл ажиллагаатай хамааралтай 5 шалгуурт алдаа, зөрчил илрээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх БӨА-2024/01/НА-СТА-ТТЗ

Алтай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Алтай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн Шилэн дансны мэдээллээс программд орсон мэдээллүүдийн хэрэгжилтийг шалгахад мэдээллүүдийг бүрэн оруулсан байна. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 100% байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

Аудитын илрүүлэлт:

- *Сумын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар шилэн данстай холбоотой зөрчил гараагүй.*
- *Сумын ЗДТГ-ын санхүүгийн тайланд хийсэн аудитаар өмнөх оны аудитаар шилэн данстай холбоотой илэрсэн зөрчлийг арилгах талаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, тайлант онд зөрчлийг давтан гаргасан тул нягтлан бодогчид хариуцлага тооцуулах албан шаардлага өгөгдсөн байна..*

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Алтай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчид завсрын аудит хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Алтай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчил гараагүй боловч аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар бүх сумын Засаг дарга нарт малын татварын төлөвлөлт, бүрдүүлэлтийн талаар “Малын татвараас орох орлогыг үндэслэлтэй төлөвлөж, сумын ИТХ-аар батлуулж, орлогыг сумын төсвийн орлогод бүрэн төвлөрүүлж ажиллах” зөвлөмж өгсөн.

Зөвлөмжийг хэрэгжилтийг шалгахад Алтай сумын ИТХ-ын 2023 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн “Алтай сумын 2023 оны тодотгосон төсөв батлах тухай” 61 дүгээр тогтоолоор малын татварын орлогыг 9.5 сая төгрөгөөр төлөвлөж, 6.5 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 2 тусгай сан болон сумын төрийн сан, эргэлтийн эмийн сангуудын санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 1 байгууллага, 2 сангийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан.

Ерөнхий боловсролын 1 ба 2 дугаар сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв, Эрүүл мэндийн төвд орон нутгийн төсвөөс олгосон тогтмол зардлын санхүүжилтийг нэгтгэлд хамруулсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудаас Засаг даргын тамгын газрын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн. Сумын ИТХ, Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сан, Эргэлтийн эмийн сангийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулж үзсэн.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 239.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 148.9 сая төгрөгийн залруулга хийгдэж, 0.5 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөгдөж, 90.3 сая төгрөгийн зөрчилд нэг ажилтанд хариуцлага тооцуулах албан шаардлага өгөгдсөн байна.

Хүснэгт №5: Төсөвт байгууллагуудын алдаа зөрчлийн нэгтгэл /сая төгрөгөөр/

Д/Д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Алтай сумын ЗДТГ	9	239.7	7	148.9			1	90.3	1	0.5
2	Алтай сумын ИТХ										
3	Алтай сумын ОНХС										
4	Алтай сумын ХХС										
	Дүн	9	239.7	7	148.9	0	0	1	90.3	1	0.5

Эх сурвалж: Аудитын зөрчлийн мэдээ

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй.

Аудитаар зөрчил¹ илрээгүй.

1. Төлбөрийн акт

Акт тогтоогдоогүй.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөгдөөгүй.

5.3 Зөвлөмж

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Алтай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Зөвлөмж өгөгдөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Дүн		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								